



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/02

Мандалговь

U-14 насны Улсын аварга шалгаруулах 3*3
Сагсан бөмбөгийн тэмцээнд зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. U-14 Улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний зардалд шаардагдах мөнгөн хөрөнгийн төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. U-14 Улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний зардалд шаардагдах 1,328,000(Нэг сая гурван зуун хорин найман мянган) төгрөгийг биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны... сарын...-ний өдрийн А/Р/2
дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЭЮА0035 9033653

U-14 насны Улсын аварга шалгаруулах 3*3 сагсан бөмбөгийн тэмцээний зардлын
төсөв

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Эрхийн төлбөр	150,000	2	300,000
2	ДУА-УБ	21,400	10	214,000
3	УБ-ДУА	21,400	10	214,000
4	Байр, хоол	20,000*3	10	600,000
	Нийт дүн			1,328,000



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/03

Мандалговь

Шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн
ойд зориулсан хүчит бөхийн барилдаанд
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойд зориулсан хүчит бөхийн барилдааны зардалд шаардагдах мөнгөн хөрөнгийн төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойд зориулсан хүчит бөхийн барилдааны зардалд шаардагдах 250,000(хоёр зуун тавин мянган) төгрөгийг биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 сарын 11-ний өдрийн 1/23
дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралт

3ЮА0035 9033853

Шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойд зориулсан хүчит бөхийн
барилдааны зардлын төсөв

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Хөлийн цэц	30,000	1	30,000
2	Гарийн даа	30,000	1	30,000
3	Тайлбарлагч	30,000	1	30,000
4	Засуул	30,000	4	120,000
5	Тавгийн идээ	40,000	1	40,000
	Нийт дүн			250,000



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023 оны Дундговь аймгийн иргэдийн спортын наадам болон аймгийн аварга шалгаруулах тэмцээний медиалын зардалд 13.500.000 (Арван гурван сая таван зуун мянган) төгрөгийг хавсралтаар батлаж зарцуулсугай.

2. Материалын зардалд шаардагдах 9.000.000 (Есөн сая) төгрөгийг биеийн тамир, уралдаан тэмцээний бараа үйлчилгээний бусад зардлаас 4.500.000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг Нийтийн биеийн тамирын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *А.ОТГОНБААТАР* А.ОТГОНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 сарын 16 ны өдрийн 17/04
дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралт

2023 оны Дундговь аймгийн иргэдийн спортын наадам болон аймгийн аварга
шалгаруулах тэмцээний медалын зардалд гаргах төсөв

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Медаль	1125	12,000	13,500,000
	Нийт			13,500,000



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Олимпын таеквондогийн 2023 оны тоот дасгалын улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгаас оролцох тамирчдын төсөв гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Таеквондо Пүмсэ улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд шаардагдах 1,500,000(нэг таван зуун мянган) мөнгөн хөрөнгийн төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Таеквондо Пүмсэ улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд шаардагдах эрхийн төлбөрт 1,000,000(нэг сая) төгрөгийг шатахууны зардал 500,000(таван зуун мянган) төгрөгийг биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 сарын 19 ний өдрийн 0105
дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралт

310A0035 9033653

Олимпын таеквондогийн 2023 оны тоот дасгалын улсын аварга шалгаруулах
тэмцээнд дундговь аймгаас оролцох тамирчдын төсөв

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Эрхийн төлбөр	40,000	25	1,000,000
2	Шатахуун	500,000	1	500,000
	Нийт			1,500,000



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/06

Мандалговь

Идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах
волейболын тэмцээнд зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Волейболын идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд шаардагдах мөнгөн хөрөнгийн төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Волейболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд шаардагдах 1,900,000(Нэг сая есөн зуун мянган) төгрөгийг биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.О.З. А.ОТГОНБААТАР





ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1/07

Мандалговь

Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйл, Эрүүл мэнд нийгмийн хамгаалын сайдын 2000 оны 213 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын газрын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг тус байгууллагын албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын газрын даргын 2021 оны 07 дүгээр сарын 05-ний өдрийн А/12 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.О. А.ОТГОНБААТАР



ЗЮА0035 9033653

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны... сарын 21 -ны өдрийн...
дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЗЮА0035 9033653

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Биеийн тамир спортын газрын /цаашид газар гэх/ хөдөлмөрийн харилцаанаас үүсэх аливаа асуудлыг Монгол Улсын Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, хууль болон бусад хууль тогтоомж Засгийн газрын тогтоол тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн акт энэхүү дотоод журмаар дагаж мөрдөнө

1.2 Хөдөлмөрийн дотоод журмын зорилго нь газрын үйл ажиллагааг хэвийн явуулах хүний нөөцийн бодлого барьж ажиллах ажилтныг давтан сургах, ажилд авах, чөлөөлөх, ажлын байрны тодорхойлолтыг оновчтой зөв тодорхойлох ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангах ёс зүй, дэг журмыг бэхжүүлэх талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

Хоёр. Хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Биеийн тамир спортын газрыг дарга удирдана.

2.2 Газрын бүтцийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо болон аймгийн засаг даргын баталсан орон тооны дагуу зохион байгуулна.

2.3 Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо болон аймгийн засаг даргын баталсан орон тоонд нийцүүлэн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан гаргаж Биеийн тамир, спортын газрын даргаар батлуулна.

2.4 Газар нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвэлмэл хуудастай байх ба албан бичиг хөтлөх журмыг мөрдөж ажиллана.

2.5 Даргын дэргэд зөвлөх эрхтэй удирдлагын зөвлөх баг /цаашид даргын зөвлөл гэнэ/ ажиллана.

2.6 Зөвлөл нь 5 гишүүнтэй байх ба гишүүдийн ажилчдын нийтийн хурлаар сонгон даргын тушаалаар баталгаажуулна.

2.7 Даргын зөвлөл үйл ажиллагаа явуулах журамтай байна.

2.8 Газрын даргын эзгүйд даргын зөвшөөрсөнөөр ахлах мэргэжилтэн түр орлон гүйцэтгэнэ.

2.9 Газрын дарга долоо хоног бүрийн нэг дэх өдрийн 10.00 цагт шуурхай хурал хийж ажилчдыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 563

Мандалговь

Албан хаагчдын 2023 оны цалин,
нэмэгдлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57,2,2, 57,2,4 дэх "Төрийн албан хаагчийн цалин хөлс", Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журам, 2022 оны 487 дугаар тогтоол, Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох, 2022 оны 488 дугаар тогтоол, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох, 2022 оны 489 дүгээр тогтоол, Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах, 2022 оны 491 дүгээр тогтоол, Журамд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 192 дугаар тогтоол, Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын цалин, нэмэгдлийг хавсралтанд зааснаар шинэчлэн тогтоож 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Дашбилэг)-т үүрэг болгосугай.

3. Тогтоогдсон орон тоо, цалинг хууль тогтоомжийн дагуу батлагдсан төсөвт багтаан тооцон олгож байхыг нягтлан бодогч Б.Мөнхбаярт зөвшөөрсүгэй.

4. Биеийн тамир, спортын газрын даргын 2022 оны 06-р сарын 25-ний өдрийн Б/25 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *А.О.З* А.ОТГОНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 сарын 16 өдрийн 013 тоот
Тушаалын хавсралт



Албан хаагчдын цалин, нэмэгдлийн жагсаалт

№	Овог нэр	Албан тушаал	Төрд ажилласан сар	Цалингийн шатлал	Үндсэн цалин	Зэргийн нэмэгдэл	ЭБАТ-н	ТЗ Нэмэгдэл	Удаан жил
1	Балдан Дашбилэг	Хүний нөөц, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	157	T3-8	853375	22%	10%	20%	11%
2	Болдбаатар Мөнхбаяр	Нягтлан бодогч	46	TУ-8	861490				3%
3	Содномдаржаа Цолмон	Нийтийн биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн	301	T3-9	791532	22%		20%	25%
4	Доржсүрэн Болор-Эрдэнэ	Волейболын дасгалжуулагч	97	TУ-6	766540				8%
5	Оюунгэрэл Буянтогтох	Сагсан бөмбөг дасгалжуулагч	131	TУ-6	766540				10%
6	Отгонбаяр Цэрэнлхам	Архив, бичиг хэргийн ажилтан, нярав		TУ-5	686638				
7	Өөдес Занабазар	Арга зүйч	271	TУ 6	766540				23%
8	Дамдин-Очир Мягмаржав	Бөхийн дасгалжуулагч	12	TУ 6	766540				
9	Содномцэрэн Лувсандорж	Жижүүр	156	TУ 1	565277				13%
10	Цэндсүрэн Майдармаа	Үйлчлэгч	249	TУ-1	565277				20%
11	Осор Хатанбаатар	Жижүүр	6	TУ-1	565277				

12	Нямсүрэн Доржбат	Жижүүр, мужаан	39	ТҮ-1	565277			3%
13	Даваадорж Дуламсүрэн	Үйлчлэгч	9	ТҮ-1	565277			



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 5/04

Мандалговь

Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл
олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4 дэх заалт, 2018 оны 12-р сарын 19-ний өдрийн 382-р тогтоолын 4-р хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төлөвлөгөөт ажлыг санаачилгатай, үр бүтээлтэй хэрэгжүүлж ажилласан даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Отгонбаатар, арга зүйч Ө.Занабазар, үйлчлэгч Ц.Майдармаа, үйлчлэгч Д.Дуламсүрэн нарт 20 хувь, дасгалжуулагч Д.Болор-эрдэнэ, дасгалжуулагч О.Буянтогтох, жижүүр С.Лувсандорж, жижүүр С.Хатанбаатар нарт 10 хувийн ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Дээрх ажилчдад ур чадварын нэмэгдлийг журмын дагуу олгохыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А.ОТГОНБААТАР